



Ерөнхийлөгч Томас С.Монсон

Хөлийнхөө доорх замыг хар

Бид Есүсийг өөрсдийн Жишээ болгож, Түүний мөрөөр алхсанаар Тэнгэрлэг Эцэгтээ аюулгүй буцан очиж чадна.

Хайрт ах, эгч нар аа, би энэ өглөө та нарын өмнө зогсож байгаадаа даруусч байна.

Захиасаа хуваалцах үед маань итгэлтэй байж, миний өмнөөс залбирахыг би та нараас хүсэж байна.

Бид бүгд сүнсний дэлхийг орхиж, сорилт бэрхшээлээр дүүрэн мөнх бус энэ дэлхийд ирэхдээ гайхамшигтай, мөн чухал аяллыг эхэлсэн билээ. Энэ дэлхий дээрх бидний оршин буйн хамгийн гол зорилго нь мах болон ясан биеийг хүлээн авч, зөвхөн Тэнгэрлэг Эцэг, эхээсээ тусгаарлагдсанаар хүлээн авах боломжтой туршлагыг хуримтлуулж, зарлигуудыг сахих эсэхээ харуулах явдал юм. Бид Абрахамын номын 3-р бүлгээс “Мөн Их Эзэн, тэдний Бурхан тэдэнд зарлиглах бүх зүйл юуг ч гэсэн тэд хийх нь үү гэдгийг харахын тулд үүгээр бид тэднийг нотлох болно” хэмээн уншдаг.¹

Бид дэлхий дээр ирэхдээ Бурханаас өгсөн агуу бэлэг болох сонгох эрхийн хамт ирсэн юм. Бид мянга

мянган арга замаар өөрсдийнхөө төлөө сонгох эрхтэй байдаг. Энд бид хувийн туршлага хэмээх хүнд хэцүү багшаас суралцдаг. Бид сайн, муут хооронд нь ялган таних чадвартай байж, гашуун болон чихэрлэг амтыг ч ялгаж сурдаг. Бид шийдвэрүүд хувь заяаг тодорхойлдогийг ойлгож авдаг.

Эцэгийн бидний төлөө төлөвлөсөн, мөн бид өөрсдөө маш ихээр хүссэн өргөмжлөлийг авч болохын тулд бид Түүн рүү буцаж очих асар их хүсэл эрмэлзэл тээн, өөрсдийн Эцэгийг орхисон гэдэгт би итгэлтэй байна. Хэдийгээр бид Тэнгэр дэх Эцэг рүүгээ буцаж очиход хөтлөх замыг олж, мөн дагах ёстой болсон ч, Тэрээр биднийг удирдамж, чиглүүлэлгүйгээр орхиогүй юм. Харин Тэр бидэнд хэрэгтэй арга хэрэгслүүдийг өгсөн ба бид Түүний тусламжийг эрэлхийлж, эцсээ хүртэл тэвчин, мөнх амьдралыг авахын тулд өөрсдийн чадах бүх зүйлийг хийхээр хичээх үед Тэр бидэнд туслах болно.

Биднийг удирдахад туслах ариун судар дээрх Бурханы болон Түүний Хүүгийн үгс бидэнд бий. Бидэнд Бурханы бошиглогчдын зөвлөгөө, сургаалууд ч байдаг. Хамгийн чухал нь, бидэнд дагах төгс үлгэр жишээ – бүр бидний Их Эзэн, Аврагчийн үлгэр жишээ байдаг. Мөн бидэнд энэхүү жишээг дагахыг зааварладаг. Аврагч Өөрөө: “Ирж, Намайг дага”² мөн “Миний хийхийг та нарын харсан тэр ажлуудыг та нар түүнчлэн хийх болно”³ гэж хэлсэн. Тэрээр “Та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ?” хэмээн асуугаад, “Үнэнээр би та нарт хэлье, бүр миний адил буюу”⁴ хэмээн хариулсан билээ. “Тэрээр замыг бидэнд үзүүлсэн ба өөрөө уг замаар явсан.”⁵

Бид Есүсийг өөрсдийн Жишээ болгож, Түүний мөрөөр алхсанаар Тэнгэрлэг Эцэгтэйгээ үүрд мөнхөд хамт амьдрахаар Түүн рүү буцаж очиж чадна. Бошиглогч Нифай “Үүгээр хүмүүн амьд Бурханы Хүүгийн жишээг дагахдаа эцсээ хүртэл тэвчихээр бусдаар бол, тэр аврагдаж чадахгүйг би мэднэ”⁶ гэж хэлсэн байдаг.

Нэгэн эмэгтэй Ариун нутаг дахь аяллынхаа туршид олж авсан өөрийн туршлагын талаар ярих бүрдээ “Би Есүсийн алхсан газраар алхсан!” гэж хэлдэг байлаа.

Тэрээр Есүсийн амьдарч, мөн зааж байсан газар байсан байж болох юм. Тэр Түүний зогсож байсан хадан дээр зогсож, харж байсан уул нуруудыг нь харсан байж ч магадгүй. Эдгээр туршлага нь түүнд л сэтгэл догдлом санагдаж байсан байх. Гэвч Есүсийн алхаж байсан маягаар алхах нь Түүний алхаж

байсан *газраар* алхахаас илүү чухал юм. Түүний үйлдлүүдийг дуурайж, үлгэр жишээг дагах нь Түүний мөнх бус байдалдаа аялж байсан газраар явахаас хавьгүй илүү чухал билээ.

Есүс нэгэн баян эрд “Ирж, Намайг дага”⁷ хэмээх урилгыг өгөхдөө зөвхөн уул нурууд, хөдөө нутгаар дагаж явахыг хэлээгүй юм.

Бид Есүсийн аялсан Галилын эргээр, эсвэл Иудейн уулархаг нутгаар аялах шаардлагагүй. Түүний үгс бидний чихэнд хоногшиж, Сүнс нь бидний зүрх сэтгэлийг дүүргэн, Түүний сургаалууд бидний амьдралыг удирдах ба бид мөнх бус аялын үеэр Түүнийг дагахаар сонгох үед бидний хүн нэг бүр Түүний явсан замаар явж чадна. Түүний үлгэр жишээ замыг гэрэлтүүлдэг. Тэрээр “Би бол зам, үнэн, амь мөн”⁸ гэж хэлсэн билээ.

Бид Есүсийн явж өнгөрсөн замын тухай бодох үед Тэрээр энэ амьдралд бидний туулдаг олон сорилт бэрхшээлийг ч бас туулсан болохыг мэдэх болно.

Жишээлбэл, Есүс гашуудлын замаар алхсан. Тэр маш олон удаа гашуудаж байсан ба Иерусалим дахь олон нийтэд номлосон номлолоо дуусгах үедээ Иерусалимын төлөө гашуудсан нь хамгийн сэтгэл хөдөлгөм байдаг. Израилийн хүүхдүүд Түүний санал болгосон, хамгаалагч мутрын аюулгүй байдлыг эсэргүүцсэн юм. Тэрээр удахгүй устгагдах хотыг хараад, гүн гүнзгий гашуудалд автсан. Тэрээр ихэд зовж шаналан, “Иерусалим аа, Иерусалим аа, өөрт нь илгээгдэгсдийг чулуудан, эш үзүүлэгчдийг алдаг хот оо! Тахиа дэгдээхийнүүдээ далавчин дороо бөөгнүүлдэгчлэн Би хүүхдүүдийг чинь цуглуулахыг хичнээн их хүсэв. Гэтэл та нар хүссэнгүй!”⁹ хэмээн дуу алдсан байдаг.

Есүс уруу таталтын замаар алхсан. Люсифер хамгийн агуу хилэнцэт хүч чадлаа шавхан, хамгийн сэтгэл татам худал үгсээ ашиглаад 40 өдөр, мөн 40 шөнө мацаг барьсан Түүнийг уруу татахыг оролдсон юм. Есүс бууж өгөөгүй бөгөөд

харин ч уруу таталт бүрийг эсэргүүцэж байлаа. Тэрээр “Зайл, Сатан аа”¹⁰ гэж эцсийн үгээ түүнд хэлсэн юм.

Тэрээр өвчин шаналлын замаар алхсан. Түүний “зовж, шаналж байсан . . . түүний хөлс нь цусны дусал мэт газарт дусалж бай[сан]”¹¹ Гетсеманий талаар бодоод үз. Хэн ч харгис хэрцгийг загалмай дээрх Түүний зовлон шаналлыг мартаж чадахгүй.

Бидний хүн нэг бүр алдсан боломжууд ба ашиглаагүй хүч чадлаасаа болж, мөн хайртай хэн нэгнийхээ юм уу, өөрсдийнхөө сонголтоос болж гашуудлын замаар алхаж магадгүй. Мөн бид уруу таталтын замаар ч алхах болно. Бид Сургаал ба Гэрээний 29-р хэсгээс: “Мөн чөтгөр хүмүүний үрсийг уруу татах ёстой нь шаардлагатай ажгуу, эс бөгөөс тэд өөрсдийнхөө төлөө сонгогч байж эс чадна”¹² хэмээн уншдаг.

Мөн бид өвчин шаналлын замаар алхах болно. Бид үйлчлэгчдийн хувьд агуу өвдөлт, зовлон шаналлыг эдэлсний дараа мөнх бус байдлыг орхисон Эзнийхээс илүү өвдөлт бидэнд ирэх байх гэж бодох хэрэггүй.

Бид өөрсдийн замд гашуун гуниг харуусалтай тулгарахдаа агуу баяр баясгаланг мөн олж чадна

Бид Есүстэй хамт дуулгавартай байдлын замаар алхаж чадна. Энэ нь үргэлж амархан байхгүй ч, “Харагтун, дуулгавартай дагах нь тахил өргөхөөс илүү, сонсож дагах нь хуцын өөхнөөс илүү”¹³ хэмээх Самуелийн бидэнд өгсөн өвийг өөрсдийн уриа болгоцгооё. Дуулгаваргүй байдлын эцсийн үр дүн нь боолчлол мөн үхэл байдаг бөгөөд дуулгавартай байдлын шагнал нь эрх чөлөө ба мөнхийн амьдрал байдаг гэдгийг санацгаая.

Бид Есүстэй адил үйлчлэлийн замаар алхаж чадна. Сайн сайхны агуу үлгэр жишээ нь хүмүүсийн дунд номлож байсан Есүсийн амьдрал юм. Тэрээр доголон нэгний хөлөнд хүч, сохор нэгний нүдэнд

хараа, дүлий нэгний чихэнд сонсгол авчирсан юм.

Есүс залбирлын замаар алхаж байсан. Тэрээр Их Эзний залбирал хэмээх бидний мэддэг гайхамшигт залбирлыг бидэнд өгснөөр хэрхэн залбирахыг бидэнд заасан юм. Мөн Гетсемани дахь “Миний хүсэл бус, харин Таны хүсэл биелэгдэг”¹⁴ гэсэн Түүний залбирлыг хэн мартаж билээ?

Аврагчийн бидэнд өгсөн бусад судар дээрх заавар бидний гар дээр бэлэн байдаг. Тэрээр Уулан дээрх номлолынхоо үеэр бидэнд нигүүлсэнгүй, даруу, зөв шударга, зүрх сэтгэлдээ цэвэр ариун, амар тайвныг тогтоогч бай гэж хэлсэн билээ. Тэрээр бидэнд бүр доромжуулж, хавчигдаж байсан ч өөрсдийнхөө итгэл үнэмшлийн төлөө зоригтой зогсохыг зөвлөдөг. Тэрээр биднээс бусад хүн харж болохын тулд, мөн Тэнгэр дэх Эцэгийг алдаршуулж болохын тулд гэрлээ гэрэлтүүлэхийг хүсдэг. Тэрээр бидэнд бодол санаа болон үйл хөдлөлдөө ариун журамтай байхыг заадаг билээ. Тэрээр дэлхий дээр бус, тэнгэрт эрдэнэс нөөцлөх нь илүү агуу чухал гэж хэлдэг.¹⁵

Түүний сургаалт зүйрлэлүүд хүч, эрх мэдэлтэйгээр заадаг. Тэрээр сайн самари хүний түүхээр дамжуулан бидэнд хөршөө хайрлаж, үйлчлэхэд сургадаг.¹⁶ Тэрээр талантуудын сургаалт зүйрлэлээрээ бидэнд өөрсдийгөө хөгжүүлж, төгс төгөлдөрт хүрэхийн төлөө хичээхийг заадаг.¹⁷ Тэрээр алдагдсан хонины тухай сургаалт зүйрлэлээр бидэнд замаа орхиж, зүг чигээ алдсан хүмүүсийг аврахаар явахыг зөвлөдөг.¹⁸

Бид Түүний үгсээс суралцаж, сургаалуудыг нь дагаж, Түүний замаар алхсанаар Христийг амьдралынхаа төвд байрлуулахыг хичээх юм бол Тэрээр олж авахын тулд амиа өгсөн мөнхийн амьдралаа бидэнтэй хуваалцах болно гэж амласан юм. Бид Түүний сахилга батыг хүлээн авч, Түүний шавь нар болж, амьдралынхаа туршид Түүний ажлыг хийхээс

илүү дээр төгсгөл гэж байхгүй. Өөр юу ч, бидний хийх өөр ямар ч сонголт Түүний хийж чадах зүйлийг хийж чадахгүй.

Намайг Аврагчийн үлгэр жишээг дагахыг үнэнээсээ хичээж, Түүний замаар алхсан хүмүүсийн тухай бодох бүрд миний мэдэхээр, Христийнхтэй хамгийн адил зан чанартай хүмүүс болох Густав ба Маргарит Вокэр нар бодол санаанд минь орж ирдэг юм. Тэд Зүүн Канадад цагаачилсан уугуул герман хүмүүс байсан бөгөөд би тэнд номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байхдаа тэдэнтэй танилцсан юм. Вокэр ах үсчин хийж, амьжиргаагаа залгуулдаг байв. Тэдэнд тийм ч их мөнгө байгаагүй ч байгаа бүх зүйлээ хуваалцдаг байж билээ. Тэд хүүхдүүдээр адислагдаагүй ч, гэрт нь ирсэн хүн бүрийг халамжилдаг байсан. Өндөр боловсролтой, ухаалаг эрэгтэй, эмэгтэйчүүд хүртэл эдгээр даруу, мөн боловсрол муутай Бурханы үйлчлэгчийг зорьж ирдэг байсан бөгөөд тэдэнтэй нэг цаг ч гэсэн хамт байгаадаа өөрсдийгөө азгайд тооцдог байв.

Тэдний гадаад төрх эгэл даруу, англи хэл нь төгс биш, ойлгоход хэцүү, мөн гэр орон нь ч тун энгийн байсан юм. Тэдэнд машин ч, зурагт ч байгаагүй бөгөөд тэд дэлхийн анхаарал хандуулдаг зүйлийг хийдэггүй байлаа. Итгэлтэй хүмүүс тэнд байсан сүнсийг мэдрэхийн тулд тэдэн дээр ойр ойрхон зочилж очдог байв. Тэдний гэр дэлхий дээрх диваажин байсан бол, тэдний авчирдаг сүнс жинхэнэ амар амгалан, сайн сайхан байсан юм.

Бид ч мөн Аврагчийн замаар алхаж, төгс үлгэр жишээг нь дагахдаа энэ сүнстэй хамт байж, үүнийг дэлхийтэй хуваалцаж чадна.

Бид Сургаалт үгсээс “Хөлийнхөө доорх замыг хар”¹⁹ хэмээн уншдаг. Үүнийг хийснээр бид итгэлтэй бөгөөд Есүсийн алхсан замаар алхах хүсэлтэй байх болно. Мөн бид Эцэгийнхээ дага хэмээн өгсөн зам дээр байгаа гэдэгтээ эргэлзэхгүй байх болно. Аврагчийн үлгэр жишээ бидний хийдэг бүх зүйлийн үндэс суурь бөгөөд Түүний үгс найдвартай удирдамж өгдөг. Түүний зам

биднийг гэр рүү маань аюулгүй хүргэж өгөх болно. Энэ адислалыг бид хүртэх болтугай хэмээн би өөрийнхөө хайрладаг, үйлчилдэг, мөн гэрчилдэг Есүс Христийн нэр дээр залбирч байна, амен.

ЭШЛЭЛҮҮД

1. Абрахам 3:25.
2. Лук 18:22.
3. 3 Нифай 27:21.
4. 3 Нифай 27:27.
5. Элиза Р.Снөү, “How Great the Wisdom and the Love,” *Hymns*, дугаар 195
6. 2 Нифай 31:16.
7. Лук 18:22.
8. Иохан 14:6
9. Лук 13:34.
10. Матай 4:10
11. Лук 22:44.
12. Сургаал ба Гэрээ 29:39.
13. 1 Самуел 15:22.
14. Лук 22:42.
15. Матай 5:6-ийг үзнэ үү.
16. Лук 10:30-37-г үзнэ үү
17. Матай 25:14-30-ийг үзнэ үү.
18. Лук 15:4-7-г үзнэ үү.
19. Сургаалт Үгс 4:26

Бидэнд зориулсан сургаал

2014 оны 10-р сараас 2015 оны 4-р сар хүртэлх Мелкизедек санваартнуудын болон Халамжийн Нийгэмлэгийн дөрөв дэх Ням гаргийн хичээлийг 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсээс нэгийг юм уу, түүнээс илүүг сонгон бэлтэж заана. 2015 оны 4-р сард 2014 оны 10-р сарын эсвэл 2015 оны 4-р сарын чуулган дээр хэлсэн үгсээс алиныг нь ч сонгон зааж болно. Гадас, дүүргийн ерөнхийлөгчид заах хэлсэн үгийг сонгоно, эсвэл энэ үүргийг бишоп, салбарын ерөнхийлөгчид даалгаж болно.

Эдгээр хэлсэн үгийг conference.lds.org хаягаар олон хэлээр унших боломжтой.



Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх

Гэрэл ба үнэний талаар гэрчлэл хүлээж авах нь

*Гэрэл ба үнэний талаарх таны гэрчлэл таныг
болон таны үр удмыг энэ амьдралын турш адислаад
зогсохгүй, мөнх амьдралд тань ч хамт дагалдах болно.*

Би онгоцны нисгэгч байхдаа шөнийн түнэр харанхуйд тив, далайг гатлан; олон цагийн нислэг хийж байсан. Нисгэгчийн бүхээгээс шөнийн тэнгэрийг ширтэн харах болгонд, тэр тусмаа тэнгэрийн заадсыг харахад Бурханы бүтээл хэчнээн өргөн цар хүрээтэй, гүн гүнзгий болохыг, мөн сударт дүрслэгдсэн шиг “тоо томшгүй олон дэлхий”¹ байдгийг гайхширан, бахархах сэтгэл төрдөг байлаа.

Ихэнх одон орон судлаач тэнгэрийн заадсыг цорын ганц одны аймаг хэмээн таамагладаг байсан цагаас хойш хагас зуун жил хүрэхгүй хугацаа өнгөрчээ.² Тэд манай одны аймгаас цааш од эрхэс, гэрэл гэгээ, амь амьдрал гэж байхгүй бөгөөд эзэнгүй, хүйтэн, юу ч үгүй, эцэс төгсгөлгүй хоосон орон зай л байдаг хэмээн төсөөлж байлаа.

Дуран авай улам хөгжин, боловсронгуй болж, түүнийг сансрын уудамд хөөргөснөөр, одон орончид гайхамшигтай бөгөөд хүн ойлгон хүлээн авахад ч бэрх үнэнийг буюу орчлон ертөнц нь бидний итгэж, таамаглаж байснаас ч илүү, хүний оюун ухаанд багтамгүй асар том болох тухай; мөн сансар огторгуй нь тэртээ хол орших, хэдэн зуун тэрбум од эрхэсээс болон тоо томшгүй, түм буман одны аймгаас бүрддэг тухай ойлгож эхэлжээ.³

Орчлон ертөнцийн тухай бидний ойлголт маш богино хугацаанд эрс өөрчлөгдсөн юм.

Өнөөдөр бид асар хол орших тэдгээр одны аймгаас заримыг нь харах боломжтой болжээ.⁴

Тэнд үнэхээр одны аймгууд байгаа гэдгийг бид мэднэ.

Эдгээр одны аймгууд байгаа газартаа маш урт удаан хугацааны турш оршсоор ирсэн юм.

Гэхдээ хүн төрөлхтөн тэнгэр дэх гэрлийг хурааж, одны аймгийг харах боломж олгодог хүчирхэг төхөөрөмжүүдийг зохион бүтээхээс өмнө бид сансрын уудамд одны аймгууд байдгийг огт мэддэггүй байлаа.

Орчлон ертөнц гэнэт асар том болж өөрчлөгдөөгүй, харин энэхүү үнэнийг харж ойлгох бидний чадвар л ихээхэн өөрчлөгдсөн юм. Тэрхүү илүү агуу гэрлийн ачаар урьд өмнө төсөөлж ч байгаагүй гайхамшигт боломж хүн төрөлхтөнд нээгдсэн билээ.

Харахгүй байгаа зүйлдээ итгэх нь хэцүү

Та өөрийгөө цаг хугацааг буцааж, мянга юм уу зуун жилийн өмнөх хүмүүстэй уулзаж учрах чадвартай гэж төсөөлөн бод доо. Мөн та өөрийгөө бидний энэ үед өргөн хэрэглэгдэж байгаа орчин үеийн техник технологийг тэдэнд дүрслэн тайлбарлах гэж байна гэж бод. Жишээ нь, бид тэдэнд бага оврын нисэх онгоц, богино долгионы зуух, өргөн хүрээтэй цахим сан бүхий хэрэгслүүдийн тухай болон сая сая хүнтэй шууд хуваалцаж болдог, бидний ач зээ нарын тоглодог видео тоглоомын талаар ярьж өгвөл тэр хүмүүс бидний талаар юу гэж бодох бол?

Зарим нь бидэнд итгэх байх л даа. Харин олонх нь биднийг дооглон тохуурхаж, үгүйсгэж, мөн бидний амыг таглах гэж оролдох юм уу, зодож цохиж ч магадгүй.

Зарим нь биднийг төөрөгдөлд орсон, ухаан мулгуу эсвэл бүр аюултай хүмүүс хэмээн нотлох гэж өөрсдийн мэдэх логик, учир шалтгаан, баримт сэлтийг ашиглах гэж оролдох байх. Тэд биднийг бусдыг төөрөгдүүлэх гэж байна хэмээн буруутгаж ч магадгүй юм.

Мэдээж, тэр хүмүүс бидний талаар буруу ойлголттой байгаа нь үнэн. Гэхдээ тэд бидэнд сайныг хүсэж, чин сэтгэлээсээ хандсан байж ч болно. Тэд өөрсдийнхөө үзэл бодлыг туйлын үнэн хэмээн бодож байгаа шүү дээ. Шулуухан хэлэхэд, тэд илүү бүрэн дүүрэн үнэний гэрлийг одоогоор олж аваагүй байгаа учраас бидний хэлсэн зүйлийг тодорхой харж, ойлгох боломжгүй юм.

Гэрэл өгөгдөх тухай амлалт

Буруу байсан ч зөв хэмээн бодох нь хүмүүний нэгэн зан чанар болов уу. Хэрвээ тийм л юм бол итгэл найдвар бидэнд ямар хэрэгтэй юм бэ? Хоорондоо зөрчилтэй өдий төдий үзэл бодол байдаг учраас, мөн бид зөвхөн өөрсдийн ойлголт, итгэл дээр тулгуурлан, үнэнийг мэдэхгүйгээр амьдарч болно гэж үү?

Үнэнийг олж мэдэх боломжтой юу?

Энэ бүхнийг та бүхэнтэй хуваалцсан миний зорилго бол бүх үнэнийг мэддэг Түмэн цэргийн Бурхан Эзэн Өөрөө, бид үнэнийг өөрсдөө олж мэдэх боломжтой гэсэн амлалтыг үр хүүхдүүддээ өгсөн тухай баярт мэдээг тунхаглах явдал юм.

Энэхүү чухал сүнслэг бэлгийн ач холбогдлын талаар эргэцүүлэн бодоорой.

Үүрдийн бөгөөд Бүхнийг Чадагч Бурхан, энэхүү өргөн уудам орчлон ертөнцийг Бүтээгч нь Түүнтэй чин сэтгэлээсээ, шийдвэр төгс хандсан хүмүүстэй ярьдаг.

Тэрээр тэдэнтэй зүүд, зөн билэг, бодол санаа, зүрх сэтгэлд нь ярих болно.

Тэрээр хэрхэвч алдаж будилахын аргагүй, хүмүүний төсөөлөлд багтаж ч байгаагүй тийм арга замаар ярьдаг. Тэрээр тэдний хувийн

амьдралд хамаатай бурханлаг заавар, хариултыг өгөх болно.

Мэдээж, ийм зүйл байх боломжгүй, Бурхан гэж байдаг л юм бол Түүнд ганц нэг хүний залбирлыг сонсож хариулахаас илүү чухал ажил байдаг байлгүй дээ хэмээн элэглэн дооглох хүмүүс ч гарч ирж магадгүй юм.

Гэхдээ би та нарт: Бурхан таны төлөө санаа тавьдаг. Тэрээр таныг сонсдог бөгөөд хувийн асуултуудад тань хариулах болно. Таны залбирлын хариу Түүний арга замаар, Түүний цагт ирэх учир та Түүний дуу хоолойг сонсож сурах хэрэгтэй. Бурхан танаас Түүн рүү буцаж очих замаа олоосой гэж хүсдэг бөгөөд тэр зам нь Аврагч мөн болой.⁵ Бурхан та бүхнийг Түүний Хүү, Есүс Христийн талаар олж мэдэн, бурханлаг шавь байх замыг дагаснаар танд ирэх амар амгалан, баяр баяслыг мэдрээсэй хэмээн хүсдэг.

Хүндэт найз нөхөд минь, үүнийг шалгаж үзэх гэсэн эрэгтэй, эмэгтэйчүүд, хүүхдүүд зэрэг хүн бүхэнд зориулсан Бурханы амлалт бүхий энгийн нэгэн туршилтын талаар эртний судраас олж уншиж болно:

Нэгд, та Бурханы үгийг эрэлхийлэх ёстой. Энэ нь судруудыг уншиж, эртний болон орчин үеийн бошиглогчдын Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний талаарх үгсийг үгүйсгэж маргах зорилгоор бус, харин үнэнийг олж мэдэх гэсэн чин сэтгэлээр судлахыг хэлдэг. “Өөрт тань мэдрэгдэх зүйлсийн талаар эргэцүүлж, үнэнийг хүлээн авахын тулд оюун санаагаа бэлтгэ.⁶ “. . . Бүр та нарт итгэх хүслээс илүү нь байхгүй ч гэсэн, энэ хүслийг өөрсөддөө хөгжихийг, бүр . . . та нар [Бурханы үгийг] өөртөө байрлуулж чадахаар итгэлтээ зөвшөөр.⁷

Хоёрт, Адамын үеэс өнөөдрийг хүртэл Их Эзэн үр хүүхдүүддээ нигүүлсэнгүй хандаж, Өөрийн Сүмийг удирдан биднийг Түүн рүү буцаж очиход туслах бошиглогч, үзмэрч, илчлэгчдийг өгснийг та анхааралдаа авч, тунгаан бодож, зоригтой итгэхийг хүсэж,⁸ талархах ёстой.

Гуравт, та Тэнгэрлэг Эцэгээс Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн талаарх үнэнийг танд илчлэхийг Түүний Хүү, Есүс Христийн нэрээр асууж хүсэх ёстой. Тэгэхдээ Есүст итгэж; чин сэтгэл, үнэн хүсэлтэйгээр асуух ёстой билээ.⁹

Үүнээс гадна Аврагчаас бидэнд өгсөн *дөрөв* дэх үе шат бий: “Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсэж байвал тэр нь энэ сургаал Бурханаас ирсэн үү, эсвэл би Өөрөөсөө ярьж байна уу гэдгийг мэднэ.”¹⁰ Өөрөөр хэлбэл, хэрвээ та сайн мэдээний зарчмыг шалгая гэвэл, эхлээд түүний үгийн дагуу амьдрах ёстой гэсэн үг. Сайн мэдээний сургаалыг болон Сүмийн заадаг зүйлсийг амьдралдаа хэрэгжүүлж, шалгаад үз. Үүнийг чин сэтгэлээсээ, Бурханд итгэх гуйвшгүй итгэлээр хийгээрэй.

Хэрвээ та энэ бүхнийг хийж чадвал Бурхан–Өөрийн үгээр¹¹ үүрэг хүлээн авч, Ариун Сүнсний хүчээр үнэнийг үзүүлнэ хэмээн амласан билээ. Тэрээр харанхуйг нэвт харах хүчийг өгөгч илүү агуу гэрлийг танд соёрхсоноор, та мөнх бус амьдралдаа төсөөлшгүй гайхамшигт дүр зургийг гэрчлэх болно.

Зарим хүн эдгээр шатлалыг дэндүү хэцүү, эсвэл иймэрхүү хүчин чармайлт гаргах нь шаардлагагүй зүйл хэмээн хэлж болох юм. Гэхдээ сайн мэдээний тухай болон Сүмийн талаар хувийн гэрчлэлтэй болох нь таны энэ амьдралдаа олж авах ёстой хамгийн чухал зүйл мөн гэдгийг би та бүхэнд хэлмээр байна. Энэхүү гэрчлэл нь таныг зөвхөн энэ амьдралын тань турш адисалж, удирдаад зогсохгүй, таны мөнх амьдралтай ч мөн шууд холбоотой юм.

Сүнслэг зүйлсийг зөвхөн Сүнсээр л ойлгох боломжтой

Үнэнийг улам бүрэн дүүрэн ойлгоход туслах, илүү агуу гэрлийг хурааж цуглуулах боломжтой, боловсронгуй төхөөрөмжүүд бий болох хүртэл эрдэмтэн мэргэд орчлон ертөнцийн цар хүрээг ойлгох

гэж ихээхэн хичээл зүтгэл гаргасан билээ.

Төлөөлөгч Паул үүнтэй адил, сүнслэг мэдлэгийн талаарх зарчмыг заасан юм. Тэрээр коринтчуудад “Харин төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Учир нь тийм хүн эдгээрийг ойлгож чадахгүй. Яагаад гэвэл эдгээр нь сүнслэгээр үзэгддэг”¹² хэмээн бичжээ.

Өөрөөр хэлбэл, хэрвээ та сүнслэг үнэнийг олж танихыг хүсвэл зөв хэрэгсэл ашиглах ёстой. Та сүнслэг үнэнийг олж мэдрэх боломжгүй хэрэгслээр түүнийг олж мэдэх нь үгүй.

Аврагч бидний үед “Бурханаас буй нь гэрэл юм; мөн гэрлийг хүлээн авдаг мөн Бурханд үлддэг тэр нь илүү их гэрэл хүлээн авдаг; мөн тэрхүү гэрэл төгс өдрийг хүртэл улам улам хурц болон өсдөг”¹³ хэмээн хэлсэн байдаг.

Бид зүрх сэтгэл, оюун ухаанаа Бурхан руу хэчнээн их хандуулна, тэнгэрлэг гэрэл бидэн дээр төчнөөн ихээр хуралдах болно. Мөн бид тэрхүү гэрлийг сайн дураараа, чин сэтгэлээсээ эрэлхийлэх болгондоо илүү их гэрлийг хүлээн авахад бэлэн байгаагаа Бурханд нотлон харуулдаг. Урьд нь бүдэг бүрхэг, тас харанхуй, асар хол мэт байсан зүйлс танил бөгөөд тод томруун болж ирдэг.

Түүнчлэн, хэрвээ бид өөрсдийгөө сайн мэдээний гэрлээс холдуулбал, бидний гэрэл ганц хоногт юм уу, нэг долоо хоногийн дотор ч биш, харин аажим аажмаар бүдгэрч, нэг л өдөр эргэж харахдаа сайн мэдээ үнэн гэдэгт яагаад ингэтлээ их итгэж байснаа ойлгохоо больсон байдаг. Өмнө нь маш тодорхой байсан зүйлс эргээд тодорхой бус, бүдэг бүрхэг, хол хөндий болж; бидний урьд нь мэддэг байсан юмс мунхаг зүйл мэт бодогдох болсон байна.

Иймээс Паул сайн мэдээний захиас нь мөхөгсдийн хувьд мунхаг зүйл мэт боловч “аврагдаж байгаа бидний хувьд Бурханы хүч мөн”¹⁴ гэж хэлсэн.

Түвшин тогтоох шалгалт гэж байдаггүй

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүийн Сүм нь олон янзын гэрчлэлтэй хүмүүст зориулагдсан Сүм юм. Сүмийн зарим гишүүний гэрчлэл ямар ч эргэлзээгүй ба дотор сэтгэлд нь тодоос тод гэрэлтэж байдаг. Зарим хүн өөрөө олж мэдэхийн тулд эрэлхийлсээр л байдаг. Сүм нь хүмүүсийн гэрчлэл хэр гүн эсвэл хэр зэрэг өндөр түвшинд байгаагаас үл шалтгаалан хүн бүхний гэр орон нь болдог. “Та ийшээ орохын тулд гэрчлэл тань өндөр түвшинд хүрсэн байх ёстой” гэсэн тэмдэг өлгөсөн цуглааны байрыг би мэдэхгүй.

Сүм нь зөвхөн төгс хүмүүст биш, харин “Христэд ирж, мөн түүгээр төгөлдөржих”¹⁵ хүсэлтэй хүн бүхэнд зориулагдсан юм. Сүм нь тан шиг, мөн над шиг хүмүүсийнх. Сүм нь хүмүүсийг салган холдуулж, шүүмжилдэг биш, харин нөхөрсгөөр угтан авч, өргөн дэмжиж, тэтгэдэг газар билээ. Энэ бол хүн бүр бурханлаг үнэнийг эрэлхийлэх явцдаа нэг нэгнийгээ урамшуулж, сэтгэлийн дэм өгч, дэмжин тусалдаг газар юм.

Эцэст нь хэлэхэд, бид бүгд шавь болох аян замдаа Бурханы гэрлийг эрэлхийлж буй аянчид билээ. Бид бусдыг тэдэнд байгаа болон байхгүй гэрлийнх нь хэмжээгээр буруутган шүүмжилдэггүй, харин бүх гэрлийг цэвэр, тод томруун, үнэн зөв болтол нь тэжээн тэтгэж, урамшуулан дэмждэг.

Бүгдэд өгөгдсөн амлалт

Бүгд гэрчлэлтэй болох нь нэг минут, нэг цаг эсвэл нэг өдрийн ажил биш гэдгийг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Энэ нь нэг удаагийн оролдлогоор л бүтчихдэг зүйл биш юм. Сүнслэг гэрлийг цуглуулах үйл явц бол амьдралын туршид үргэлжлэх эрэл хайгуул мөн.

Амьд Бурханы Хүүгийн тухай гэрчлэл, түүнчлэн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм бол Түүний сэргээгдсэн Сүм мөн

гэсэн гэрчлэл таны хүссэнээр хурдан ирэхгүй байж болох ч, та хийх ёстой зүйлээ хийсэн байхад гэрчлэл тань ирнэ гэдгийг би амлаж байна.

Мөн тэрхүү гэрчлэл тань гайхамшигтай байх болно.

Сүнслэг үнэн нь таны зүрх сэтгэлийг дүүргэж, бодгальд тань гэрэл авчрах болно гэсэн гэрчлэлээ би хуваалцах гэсэн юм. Тэрээр танд гайхамшигт баяр баясал, тэнгэрлэг амар амгалантай хамт цэвэр оюун ухааныг нээж өгнө. Би үүнийг Ариун Сүнсний хүчээр өөрийн биеэр мэдэрсэн.

Эртний сударт бидэнд амласанчлан Бурханы Сүнсний нөхөрлөл таныг гэтэлгэх хайрын дуут дуулж,¹⁶ мэлмийгээ тэнгэр өөд чиглүүлэн, Хамгийн Дээд Бурханд буюу ирээдүйд өөрийн амьдрах газар, мөн өөрийн Найдвар ба өөрийн Хамгаалагч болох Эцэгтээ дуу хоолойгоо өргөн; Түүнийг магтан дуулахад хүргэх юм. Аврагч бидэнд хичээнгүйлэн эрэлхийлэгтүн, мөн та нар олох болно хэмээн амласан билээ.¹⁷

Би үүнийг үнэн гэдгийг гэрчилж байна. Хэрвээ та бүхэн одоогоор бүдэг бүрхэг, сүүмийх төдий, хүршгүй хол мэт санагдаж буй Бурханы үнэнийг эрэлхийлэн хайх юм бол Түүний энэрлийн гэрлийн ачаар энэ нь аажим аажмаар нээгдэж мөн тодрон томорч, зүрх сэтгэлд тань ойр болох болно гэдгийг би гэрчилж байна. Хүмүүний нүдэнд үл үзэгдэх өргөн цар хүрээтэй гайхамшигт сүнслэг байдлын дүр төрх танд илчлэгдэх болно.

Сүнслэг гэрэл нь Бурханы бүх хүүхдийн гар хүрэх газарт байгаа гэдгийг би гэрчлэх гэсэн юм. Тэр таны оюун ухааныг гэгээрүүлэн, зүрх сэтгэлийг тань илааршуулж, таны өдрүүдийг баяр баяслаар дүүргэх болно. Хайрт найзууд аа, Бурханы тэнгэрлэг ажлын тухай, тэр тусмаа гэрэл ба үнэний ажлын талаарх өөрийн гэрчлэлийг эрэлхийлж, хүчирхэгжүүлэх боломжийг бүү хойшдуул.

Гэрэл ба үнэний талаарх таны гэрчлэл таныг болон таны үр удмыг энэ амьдралд адислаад зогсохгүй, эцэс төгсгөлгүй олон дэлхийн дунд, мөн мөнх амьдралд тань ч хамт дагалдах болно. Есүс Христийн нэрээр, амен.

ЭШЛЭЛҮҮД

1. Мосе 1:33.

2. Марша Бартушак, *The Day We Found the Universe (2009)*, хii-ыг үзнэ үү. Бид гаргасан дүгнэлтдээ үргэлж итгэлтэй байж чаддагт би гайхдаг. Заримдаа бид бүх үнэнийг мэднэ хэмээн өөртөө хэт итгэдэг. Жишээ болгон, энд нэг үйл явдлыг эш татъя: Арван

есдүгээр зууны сүүлээр Америкийн одон орон судлалын тэнхимийн захирал байсан Саймон Ньюком 1887 онд, од эрхсийг ажиглах төвийн нээлт дээр хэлсэн үгэндээ: “Одон орон судлалын хувьд . . . бид мэдлэгийнхээ хязгаарт тун хурдацтай ойртож байна. Иймээс одон орон судлаачдын анхаарал үнэн хэрэгтээ шинэ нээлт хийхэд биш, харин өмнө нь олж илрүүлсэн зүйлсээ задлан шинжлэхэд чиглэж байна” гэжээ (Бартушак, xv).

3. Сүүлийн үеийн “нээлтүүд” дээр үндэслэн Мосе 1:33, 35-ыг авч үзэхэд маш сонирхолтой зүйлсийг мэдэж болно. Агуу Үнэт Сувд дээрх Мосегийн ном нь Эдвин Хаббл алс хол орших од эрхсийг олж нээснээ зарласнаас бараг зуун жилийн өмнө, 1830 оны зургаадугаар сард бошиглогч Иосеф Смитэд илчлэгдсэн билээ.

4. Тухайлбал, heritage.stsci.edu/gallery/gallery.html дээрээс Hubble Heritage Image Gallery-ийг үзнэ үү.

5. Иохан 14:6-г үзнэ үү.

6. 3 Нифай 17:3-ыг үзнэ үү.

7. Алма 32:27.

8. Сургаал ба Гэрээ 67:3-ыг үзнэ үү.

9. Моронай 10:3–5-ыг үзнэ үү.

10. Иохон 7:17; мөн Дуулаа 25: 14; Иохон 3:21-ийг үзнэ үү.

11. Сургаал ба Гэрээ 82:10-ыг үзнэ үү.

12. 1 Коринт 2:14.

13. Сургаал ба Гэрээ 50:24.

14. 1 Коринт 1:18.

15. Мороной 10:32; мөн Сургаал ба Гэрээ 10:59-ийг үзнэ үү.

16. Алма 5:26-г үзнэ үү.

17. Сургаал ба Гэрээ 88:63-ыг үзнэ үү.